
Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын Байнгын хорооны санал,
YAG-ын төлөвлөгөөний дагуу хийсэн дүн шинжилгээ

Засгийн Газрын Хэрэг эрхлэх газрын даргын багцын
2013 оны төсвийн төлөвлөлтийн байдалд хийсэн
дүн шинжилгээ

УЛААНБААТАР

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:	Товчилсон үгс.....3
ҮАГ-ын Нийцлийн аудитын газар	Дүн шинжилгээний зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....4
Ахлах аудитор	
Б.Болормаа	Бүлэг 1
	Төлөвлөгөөг боловсруулж, баталсан байдал.....5
	Бүлэг 2
2013 оны 4 дүгээр сар	Төсөл арга хэмжээний төлөвлөлтийн үндэслэл.....8
Дүн шинжилгээний тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 261740 дугаарын утас, 323266 дугаарын факсаар харилцана уу.	Зураг төсөл, тооцоо судалгаа хийгдсэн байдал.....9
	Дүгнэлт.....11
	Холбогдох байгууллагын санал12
	Зөвлөмж.....13
ХАЯГ: Үндэсний аудитын газар Засгийн газрын 4 дүгээр байр, Бага тойруу-6, Улаанбаатар-46 Монгол Улс	

ТОВЧИЛСОН ҮГС

УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар

Дүн шинжилгээний зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Дүн шинжилгээ хийх үндэслэл

Дүн шинжилгээг Улсын Их Хурлын Төрийн Байгуулалтын Байнгын хорооны санал, Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2013 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон ҮАГ-ын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Дүн шинжилгээний зорилт, хамарсан хүрээ

Засгийн Газрын Хэрэг эрхлэх газрын даргын багцын 2013 оны төсвийн төлөвлөгөөг үндэслэлтэй боловсруулж, баталсан эсэхэд дүгнэлт хийж, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах, үр дүнг олон нийтэд мэдээлэхэд дүн шинжилгээний зорилт чиглэгдэв.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр дүн шинжилгээг хийлээ. Үүнд:

- ЗГХЭГ-ын даргын багцын 2013 оны төсвийн төлөвлөлтийг зохих хуулийн дагуу төлөвлөн боловсруулж батлуулсан эсэх;
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг үндэслэлтэй төлөвлөсөн эсэх.

Монгол Улсын 2013 оны Төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2013 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт”-д тусгагдсан үйл ажиллагааг хариуцан хэрэгжүүлж буй Төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, холбогдох бусад байгууллагууд энэхүү дүн шинжилгээнд хамрагдлаа.

Дүн шинжилгээний арга зүй, хугацаа

Дүн шинжилгээнд ЗГХЭГ-ын даргын багцын 2013 оны төсвийн төслийг боловсруулах, төлөвлөх, батлах үйл явцад оролцож буй яам, агентлаг, орон нутгийн төсвийн эрх захирагч, захиалагчаас тодруулга авах, төсөл, арга хэмжээг төлөвлөх, батлуулахад шаардлагатай баримт, материалтай танилцаж, тулган баталгаажуулах арга зүйг ашиглав.

Монгол Улсын Төсвийн тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай, Монгол Улсын 2013 оны Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай болон Барилгын тухай хуулиудыг дүн шинжилгээний шалгуур үзүүлэлт болгон ашигласан.

Энэхүү дүн шинжилгээнд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг Төрийн хяналт шалгалтын стандартын дагуу ажлын баримт материалд хавсаргав. Дүн шинжилгээг 2013 оны 2 дугаар сарын 22-оос 2013 оны 3 дугаар сарын 29-ний өдрүүдэд ҮАГ-ын Нийцлийн аудитын газрын аудитын менежер Б.Алтанзул удирдан, ахлах аудитор Б.Болормаа гүйцэтгэлээ.

Бүлэг 1

Төлөвлөгөөг боловсруулж, баталсан байдал

Монгол Улсын Нэгдсэн төсвийн 2013 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2014-2015 оны төсвийн төсөөллийн тухай хуулийг үндэслэн Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2013 оны төсвийн хязгаарыг баталжээ.

Монгол Улсын 2013 оны Төсвийн тухай хуулиар Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцын хэмжээ 2013 онд 27,759.0 сая төгрөг болж, 2012 оны батлагдсан төсвөөс 19,879.4 сая төгрөгөөр буурсан байна.

Энэ нь Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт орсонтой холбогдуулж Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцад тусгагдаж байсан УИХ-ын гишүүдийн орон нутагт хэрэгжүүлсэн зарим төсөл, Хилийн чанадад амьдарч буй Монгол Улсын иргэдтэй хамтран ажиллах зөвлөлийн зарим төсөл, хөтөлбөр Эдийн засгийн хөгжлийн яаманд шилжсэнтэй холбоотой байна (Хүснэгт №1-г үзнэ үү).

Хүснэгт № 1

д/д	Төсөл, арга хэмжээний нэр	Батлагдсан төсөв (сая төг)		
		2012 он	2013 он	Зөрүү
	ЗГХЭГ-ЫН ДАРГА	47 638.4	27 759.0	19 879.4
I	Урсгал зардлын дүн	16 157.5	15 821.1	336.4
II	Хөрөнгийн зардлын дүн	31 480.9	11 937.9	19 543.0
II.1	Хөрөнгө оруулалт, барилга байгууламж	29 495.5	8 013.0	21 482.5
II.2	Тоног төхөөрөмж	1 525.4	1 636.1	(110.7)
III.3	Их засвар	460.0	1 988.8	(1 528.8)
III.4	ТЭЗҮ, зураг төсөв		300.0	(300.0)

ЗГХЭГ-ын даргын төсвийн багцад 2013 онд дараах хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнд:

- ❖ Гүйцэтгэх засаглалын удирдлага, тэдгээрийн ажлын албадын хүрээнд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэх эрх зүй, зохион байгуулалтын орчин бүрдүүлж ажиллах;
- ❖ Төр, засгийн үйлчилгээний хүрээнд УИХ, Ерөнхийлөгч, Засгийн газар, яам агентлаг үйл ажиллагаагаа хэвийн үргэлжлүүлэхэд шаардлагатай орчин, нөхцлөөр хангах;
- ❖ Соёлын өвийг бүртгэх, цуглуулах, хадгалах хамгаалах, судлан шинжлэх, олон нийтэд сурталчлах ажлын хүрээнд төр, эрх зүйн түүх, төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэгч нэгжийг судлах, төрийн түүхэнд холбогдох түүх соёлын дурсгалт зүйлсийг цуглуулах, баяжуулах, цахим мэдээллийн санг хөгжүүлж байх, дотоод гадаадын музей, соёлын байгууллагуудтай хамтран ажиллах;
- ❖ Төрийн захиргааны албан хаагчдыг мэргэшүүлэх, давтан сургах ажлын хүрээнд Төрийн албаны үйлчилгээний хүрээнд төр, бизнес, нийгмийн салбарын удирдлагаар мэргэшүүлэх болон мэргэжил дээшлүүлэх, төрийн албан хаагчдыг сургах, давтан сургах, эрдэм шинжилгээний ажил эрхлэх зэрэг арга хэмжээг хамарсан байна.

Дүн шинжилгээнд хамрагдсан төсөл, арга хэмжээнүүдийг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон Монгол Улсын нийгэм, эдийн засгийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан ба төлөвлөсөн хөтөлбөрүүдийн зорилго, зорилт, хүрэх үр дүнгийн үзүүлэлтийн тодорхойлолт, танилцуулга, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин, хүрэх үр дүнтэй уялдуулан боловсруулсан байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын багцад улсын төсвийн хөрөнгөөр 2013 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн зардлын хэмжээг 11,937.9 сая төгрөгөөр баталсан байна.

Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх нийт 30 багц төсөл, арга хэмжээний 12,895.0 сая төгрөгийн өртөг бүхий 7 багц төсөл, арга хэмжээ нь он дамжин хэрэгжих болон хэрэгжиж байгаа, 1,230.0 сая төгрөгийн өртөг бүхий 4 багц төсөл, арга хэмжээ нь 2013 онд шинээр эхэлж, хэрэгжиж дуусахаар тооцжээ. Үүнд:

д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эхлэх, дуусах хугацаа	Төсөвт өртөг	2013 онд санхүүжих
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА				
	Шилжих		12,895.0	6,783.0
1	ТЗҮААЭГ-ын харъяа автобаазын барилга /Улаанбаатар/	2012-2014	5,000.0	2,350.0
2	Аймгийн Засаг даргын Тамгын газрын барилга /Булган/	2011-2013	2,345.0	505.0
3	Аймгийн Засаг даргын Тамгын газрын барилга /Дорнод/	2011-2013	3,200.0	3,160.0
4	С.Зориг агсны нэрэмжит цэцэрлэгт хүрээлэн, дурсгалын цогцолбор /Дорнод, Дашбалбар/	2012-2013	50.0	50.0
5	Нийслэлийн бүтээн байгуулалт /Улаанбаатар, Сүхбаатар /	2012-2013	2,000.0	418.0
6	5 дугаар хорооны 18, 22 дугаар байрны дунд талбайд бичил цэцэрлэг байгуулах /Улаанбаатар, Чингэлтэй/	2012-2013	60.0	60.0
7	Сумын Засаг даргын Тамгын газар, сургууль, цэцэрлэгийн цэвэр бохир усны шугам /Дорноговь/	2012-2013	240.0	240.0
	Шинэ		1,230.0	1,230.0
1	Төрийн ордны их танхимын орчуулагчдын өрөөнүүдэд агааржуулалтын систем шинээр байгуулах	2013	50.0	50.0
2	Төрийн ордны барилгын паспортжуулалт	2013	30.0	30.0
3	Сумын Засаг даргын Тамгын газрын конторын барилга /Архангай, Хашаат/	2013	650.0	650.0
4	Сумын ЗДТГ-ын барилга /Сүхбаатар, Халзан/	2013	500.0	500.0

Нийт хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг зориулалтаар нь ангилж үзвэл, 74,2 хувийг хөрөнгө оруулалтын чанартай арга хэмжээнд, 13,8 хувийг тоног төхөөрөмжийн зардалд, 10,4 хувийг их засварын ажилд, үлдэх 1,6 хувийг бусад арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөсөн байна (Хүснэгт №2-г үзнэ үү).

Хүснэгт № 2

д/д	Төсөл, арга хэмжээний ангилал	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг (сая төг.)	Нийт дүнд эзлэх хувь
1	Хөрөнгө оруулалт	11	14 125,0	74,2
2	Их засвар	10	1 988,8	10,4
3	Тоног төхөөрөмж	8	2 636,1	13,8
4	Бусад арга хэмжээ (ТЭЗҮ, зураг төсөл)	1	300,0	1,6
	Дүн	30	19 049,9	100,0

Үүнээс улсын төсвийн хөрөнгөөр 2013 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг зориулалтаар нь ангилж үзвэл 67,7 хувийг хөрөнгө оруулалтад, 16,7 хувийг тоног төхөөрөмжид, 13,7 хувийг их засварт, 2,5 хувийг бусад арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөсөн байна (Хүснэгт №3-г үзнэ үү).

Хүснэгт № 3

д/д	Төсөл, арга хэмжээний ангилал	ТАХ-ний тоо	Санхүүжилт (сая төг.)	Нийт дүнд эзлэх хувь
1	Хөрөнгө оруулалт	11	8 013,0	67,1
2	Их засвар	10	1 988,8	16,7
3	Тоног төхөөрөмж	8	1 636,1	13,7
4	Бусад арга хэмжээ (ТЭЗҮ, зураг төсөл)	1	300,0	2,5
	Дүн	30	11 937,9	100

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцын төсөл, арга хэмжээг Үндэсний хөгжлийн цогц бодлого, Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр тооцож Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад нийцүүлэн баталсан байна.

Бүлэг 2

Төсөл арга хэмжээний төлөвлөлтийн үндэслэл

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын багцын 2013 оны төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн бодлого, зарчмыг мөрдсөн байдлыг авч үзэхэд:

Агуулга	Хэрэгжилтийн байдал
Шинээр эхлэх барилга байгууламжийн зураг төсөл, техник, эдийн засгийн үндэслэл бэлэн болсон байх	Бүрэн бус
Тухайн ТЕЗ өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг ач холбогдлоор нь эрэмбэлж ирүүлснийг хөрөнгийн зардлын батлагдсан хязгаарын тоонд багтаан авч үзэх	Бүрэн
Шинээр албан конторын болон орон сууцны барилга барихгүй байх	Бүрэн
Урьд оноос шилжин баригдаж буй барилга байгууламжийг дуусгах	Бүрэн

Батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдийг судалж үзэхэд зарим төлөвлөсөн ажил зураг төсөлгүй, ажлын зориулалт, эзэмшигч тодорхойгүй, хөрөнгө оруулалтын үр дүнг нь эргэн тооцох боломж муутай байна.

2013 онд улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх зарим барилга, их засварын ажлын хувьд тухайн барилга, байгууламжийн ашиглалт, норм, хугацаа, элэгдлийн байдал, мэргэжлийн байгууллагын гаргасан дүгнэлт, засварын хөрөнгийн төсвийг тооцсон байдлыг судлахад дараах байдалтай байна (Хүснэгт №4-г үзнэ үү).

Хүснэгт № 4

Агуулга		Төсөл арга хэмжээний тоо
Барилга, их засварын ажлыг төлөвлөхдөө тухайн барилга байгууламжийн ашиглалт, норм, хугацаа, элэгдлийн байдал, мэргэжлийн байгууллагын гаргасан дүгнэлт, засварын хөрөнгийн төсвийг тооцож үзсэн эсэх	тийм	14
	үгүй	6
	хамааралгүй	2
	Нийт	30

Дээрх хүснэгтээс үзэхэд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын багцын 2013 оны төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан зарим төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн нэр, хүчин чадал, байршил бүрэн хэмжээгээр тодорхойлогдож чадаагүй байдал ажиглагдаж байна.

Зураг төсөл, тооцоо судалгаа хийгдсэн байдал

Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх шинээр эхлэх барилга байгууламж, их засвар, хөрөнгө оруулалтын ажлуудын зураг төсөл, ТЭЗҮ хийгдсэн эсэхийг тодорхойлохдоо Барилгын тухай хуульд заасан шаардлагуудыг шалгуур болгон ашиглав.

Шинээр эхлэх барилга байгууламж, их засварын ажлуудын дийлэнх нь холбогдох шаардлагуудыг хангасан боловч зарим ажлын хувьд холбогдох тооцоо, судалгаа, ТЭЗҮ, зураг төсөл, техникийн нөхцөл тодорхой бус, холбогдох задаргаа, тооцоог ирүүлээгүй хөрөнгө оруулалтын арга хэмжээг төсвийн саналд тусгахгүй байх зарчмыг мөрдөөгүй байна. Тухайлбал,

- Архангай аймгийн Хашаат сумын Засаг даргын Тамгын газрын конторын барилгын ажлын 650, 0 сая төгрөгийг зураг төсөвгүй байхад баталсан

Зураг төсөлгүй барилга байгууламжийг улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж байгаа нь Барилгын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Зураг төсөлгүй барилга байгууламжийг улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгахыг хориглоно” гэж заасныг зөрчсөн бөгөөд зураг төсөл нь бэлэн биш, шаардагдах техникийн нөхцөл нь бүрдэж шийдэгдээгүй төсөл, арга хэмжээг төлөвлөж батлуулсан байна.

Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2-т “Хөрөнгө оруулалтын төслийн саналд үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр зэрэг холбогдох тооцоог хавсаргаж, төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлтийг гаргасан байна” гэж заасан байхад Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцын зарим арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвийг батлуулсан эсэх нь тодорхойгүй байна.

Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулж, өргөн мэдүүлсэн байдлыг судалж үзэхэд улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 22 багц нь зохих журмын дагуу, 6 багц нь судалгаа, тооцоо, ТЭЗҮ, боловсруулсан материал байхгүй, зохих журмын дагуу боловсруулж, өргөн мэдүүлээгүй төсөл, арга хэмжээ байна (Хүснэгт № 5-г үзнэ үү).

Хүснэгт № 5

Агуулга		Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх			
		барилга, байгууламж	их засвар	тоног төхөөрөмж	Нийт
Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг зохих журмын дагуу боловсруулж өргөн мэдүүлсэн эсэх	Тийм	7	8	9	24
	Үгүй	4	2	-	6
	Дүн	11	10	9	30

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын багцын 2013 оны улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын ажлын төлөвлөгөөний төслийг Төсвийн тухай хуулийн дагуу эцсийн хувилбараар бэлтгэж, Эдийн засгийн хөгжлийн яам, Сангийн яаманд хүргүүлсэн бөгөөд зарим төсөл арга хэмжээг УИХ-аар төсөв батлагдах эцсийн шатанд ЗГХЭГ-ын даргын багцад тусган батлуулсан байна. Тухайлбал,

- Архангай аймгийн Хашаат, Сүхбаатар аймгийн Халзан сумын ЗДТГ-ын барилгын ажил /500,0 сая төгрөг/;
- Хэнтий аймгийн Биндэр сумын ЗДТГ-ын барилгын засвар /136.8 сая төг/;
- Мөн аймгийн Өмнөдэлгэр сумын ЗДТГ-ын барилгын их засвар /123.2 сая төг/ зэрэг төсөл арга хэмжээний судалгаа, тооцоо байхгүй

Ийнхүү Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй” гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Дүгнэлт

Дүн шинжилгээний явцад цуглуулсан нотлох зүйлс, шинжилгээний дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Засгийн Газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2013 оны төсвийн багцад тусгагдсан улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ улс, орон нутаг, салбарын бодлого, хэтийн төлөвлөгөө, хэрэгцээ шаардлагад нийцэж байна.
2. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулахад баримтлах бодлого, зарчмыг тууштай баримтлаагүй, хийгдвэл зохих үе шатны ажлыг зарим тохиолдолд алгассанаас зураг төсөл нь бэлэн биш, захиалагч, ашиглагч, хүчин чадал, зориулалт нь тодорхойгүй зарим төсөл, арга хэмжээ хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаж батлагдсан байна.
3. Зураг төслийн талаарх Барилгын тухай хуулийн холбогдох шаардлагуудыг улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх барилга байгууламж, их засварын ажлын дийлэнх нь хангасан боловч зарим барилга, байгууламж, их засварын үр дүнг нь эргэн тооцох боломжийг судлах асуудал орхигдсон байна.

Холбогдох байгууллагын санал

МОНГОЛ УЛС ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР		
2013 он 4 дугаар сарын 23-ны өдөр	Дугаар X/176	Улаанбаатар-12 Утас: 260617 Факс: 976-11-310011
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗАРТ		
Санал өгөх тухай		
Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын багцын 2013 оны төсвийн төлөвлөлтийн байдалд ахлах аудитор Б.Болормаагийн хийсэн дүн шинжилгээний дүгнэлтийг хүлээн зөвшөөрч, өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.		
	Санхүү, хөрөнгө оруулалт, үйлчлэлгээний хэлтсийн дарга	 Ж.БЯМБАСҮРЭН

Зөвлөмж

Шинжилгээний ажлын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурьдсан албан тушаалтанд зөвлөж байна.

Нэг. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Сайханбилэгт:

1. Хөрөнгө оруулалтыг төлөвлөхдөө хууль тогтоомжоор тогтоосон шаардлагыг тууштай баримтлах, түүнд тавих хяналтыг сайжруулах.
2. Шинээр баригдах барилга, байгууламж, их засварын ажлын үр дүн, үр өгөөжийг тооцох, хэрэгжилтэд нөлөөлөх хүчин зүйл, эрсдлийг тодорхойлж, үүрэг, хариуцлагыг чангатгах арга хэмжээ авах.